



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2022.03.09 № 219

танай \_\_\_\_\_-ы № \_\_\_\_\_-г

**Г ХЭНТИЙ АЙМГИЙН ГУРВАНБАЯН Т  
ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Б.ТЭМҮҮЖИН ТАНАА**

Танай байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг албан шаардлагын хамт хүргүүлж байна.

Аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү..

Хавсралт .... хуудас

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

02303023



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванбаян тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХЭА-2022/164/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2022 он</p>	<p>Аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар Утас: 70562112</p> <p>Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390</p> <p>Аудитор: Х.Еркегүл Утас: 99040705</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	2
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. Аудитын тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	11
3.8 Аудитын гол асуудал .....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	11
4. Аудитын илрүүлэлт .....	12
4.2.1 Залруулсан алдаа.....	12
4.2.2 Албан шаардлага .....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13
6. Албан шаардлага .....	16

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2022.03.09 № 218  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын санал дүгнэлт гаргах тухай Г

Г ХЭНТИЙ АЙМГИЙН ГУРВАНБАЯН  
ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГА Б.ТЭМҮҮЖИН ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбаян тосгоны ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Гурванбаян тосгоны ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- ✓ Эрүүл мэндийн төвийн чиг үүрэгт хамааралгүй, эмийн сангийн үйл ажиллагаа явуулж нэмэлт санхүүжилтийн дансанд 12.0 сая төгрөгийн эмийн орлого, зарлагын гүйлгээг бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34 "Төсвийн байгууллага гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг"
- ✓ Нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтыг үндэслэн хөтлөөгүй ажил олгогчоос төлөх НДШ -ийн зардал 1.0 сая төгрөг төгрөг, эмийн зардал 1.4 сая төгрөгийн дансны бичилтийг алдаатай хийж цалингийн зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга"-д нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Сүхбаатар  
Төрийн  
Аудитын  
Төв

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны кол	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэ	Эцсийн үлдэгдэ
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>37,189,025.15</b>	<b>106,355,355.75</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	<b>28,518,086.47</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	<b>8,518,086.47</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	8,518,086.47
31211	Төрийн сангийн харилцах	-	8,517,307.87
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	778.60
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>463,213.00</b>	<b>42,994,092.00</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	42,994,092.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	463,213.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>36,725,812.15</b>	<b>44,644,474.28</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	15,473,189.15	18,247,203.48
35110	Тусгай зориулалттай материал	7,910,460.00	8,961,266.93
35130	Эм боох материал	7,562,729.15	9,285,936.55
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	21,252,623.00	26,397,270.80
35410	Бичиг хэргийн материал	1,313,120.00	1,728,550.00
35420	Аж ахуйн материал	8,233,106.00	8,822,756.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,043,000.00	1,320,000.00
35440	Түлш, шатах тослох материал	496,000.00	1,749,050.00
35450	Барилгын засварын материал	786,000.00	2,523,750.00
35460	Хүнсний материал	1,531,397.00	3,642,164.80
35470	Бусад хангамжийн материал	6,850,000.00	6,611,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	10,198,703.00
36100	Барааны нөөц	-	10,198,703.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>209,565,832.14</b>	<b>205,941,270.56</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	209,565,832.14	205,941,270.56
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	192,165,832.14	188,541,270.56
39201	Барилга, байгууламж, орон сууц	174,374,150.00	174,374,150.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(21,948,000.27)	(37,625,143.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	45,550,000.00	45,550,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,160,832.32)	(36,945,832.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,166,662.05	57,836,878.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	(18,736,776.51)	(25,181,494.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,427,240.80	10,347,240.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,636,982.37)	(2,208,341.18)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,636,842.04	7,636,842.04
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,506,471.28)	(5,243,029.12)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	17,400,000.00	17,400,000.00
39301	Програм хангамж	400,000.00	400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(400,000.00)	(400,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	17,400,000.00	17,400,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>246,754,857.29</b>	<b>312,296,626.31</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>5,120,780.50</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	5,120,780.50
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	5,120,780.50
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	5,120,780.50
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>246,754,857.29</b>	<b>307,175,845.81</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	246,754,857.29	307,175,845.81
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	77,796,888.00	77,796,888.00
51101	Өмч: - төрийн	77,796,888.00	77,796,888.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	77,994,273.60	138,415,262.12
51210	Өмнөх үеийн үр дүн	77,994,273.60	77,994,273.60
51220	Тайланг үеийн үр дүн	-	60,420,988.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	90,963,695.69	90,963,695.69
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>246,754,857.29</b>	<b>312,296,626.31</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>280,001,437.50</b>	<b>419,598,857.43</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>10,160,279.50</b>	<b>28,475,023.43</b>
120	Нийтлэг татварын бус орлого	10,160,279.50	28,475,023.43
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,160,279.50	28,475,023.43
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	10,160,279.50	28,475,023.43
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>269,841,158.00</b>	<b>391,123,834.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	223,417,600.00	252,162,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	223,417,600.00	252,162,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>16,489,798.00</b>	<b>108,645,834.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	108,645,834.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,489,798.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>20,758,500.00</b>	<b>25,336,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,758,500.00	25,336,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>9,175,260.00</b>	<b>4,978,200.00</b>
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	9,175,260.00	4,978,200.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>282,915,328.99</b>	<b>359,177,868.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>282,915,328.99</b>	<b>359,177,868.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>273,566,108.75</b>	<b>337,868,868.91</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>166,597,630.00</b>	<b>175,964,462.20</b>
210101	Үндсэн цалин	133,032,843.00	95,631,456.00
210102	Нэмэгдэл	22,382,322.00	62,283,563.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,037,000.00	1,507,000.00
210104	Урамшуулал	9,145,465.00	16,542,443.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>19,624,979.76</b>	<b>21,062,006.93</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,728,299.30	15,189,587.17
210202	Тэтгэмжийн даатгал	1,663,796.39	1,749,371.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,331,037.10	1,399,496.98
210204	Ажилгүйдлийн даатгал	263,804.27	247,595.58
210205	Эрүүл мэндийн даатгал	2,638,042.70	2,475,955.96
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай хөлбоотой тогтмол зардал</b>	<b>19,546,723.00</b>	<b>21,384,684.40</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,964,855.00	3,422,124.40
210302	Түши, халаалт	17,581,868.00	17,962,560.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,264,552.00</b>	<b>19,206,370.00</b>
210401	Бичиг хэрэг	1,589,280.00	1,784,570.00
210402	Тээвэр, шатахуун	7,513,350.00	9,604,850.00
210403	Шүүдэн, холбоо, интернэтийн төлбөр	612,000.00	782,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,905,702.00	3,321,600.00
210406	Бага үнэгэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	644,220.00	3,713,350.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>30,510,024.99</b>	<b>60,013,806.80</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,759,134.99	48,614,242.60
210502	Хоол, хүнс	5,994,690.00	8,113,564.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,756,200.00	3,286,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,471,860.00</b>	<b>5,031,000.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл	538,360.00	47,500.00
210604	Урсгал засвар	933,500.00	4,983,500.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>976,000.00</b>	<b>659,986.00</b>
210702	Дотоод албан томилолт	976,000.00	659,986.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>594,735.00</b>	<b>491,175.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	130,785.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,500.00	52,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19,979,604.00</b>	<b>34,055,377.58</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,529,600.00	3,887,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,450,004.00	30,168,277.58
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,349,220.24</b>	<b>21,309,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,647,035.00</b>	<b>21,300,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,647,035.00	21,300,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>123,777.00</b>	<b>9,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	123,777.00	9,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,578,408.24</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,578,408.24	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(2,913,891.49)</b>	<b>60,420,988.52</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(2,913,891.49)</b>	<b>60,420,988.52</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,796,888.00	90,963,695.69	77,994,273.60		246,754,857.29
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	77,796,888.00	90,963,695.69	77,994,273.60		246,754,857.29
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайланг үеийн үр дүн	-	-	-		-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,796,888.00	90,963,695.69	77,994,273.60		246,754,857.29
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	77,796,888.00	90,963,695.69	77,994,273.60		246,754,857.29
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	77,796,888.00	90,963,695.69	77,994,273.60		246,754,857.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайланг үеийн үр дүн	-	-	60,420,988.52		60,420,988.52
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	77,796,888.00	90,963,695.69	138,415,262.12		307,175,845.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>269,841,158.00</b>	<b>348,592,955.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>269,841,158.00</b>	<b>348,592,955.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	223,417,600.00	252,162,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	223,417,600.00	231,252,162,900.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>16,489,798.00</b>	<b>66,114,955.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	66,114,955.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,489,798.00	-
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>20,758,500.00</b>	<b>25,336,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт орон нутгийн төсөвт байгууллага	20,758,500.00	25,336,900.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>9,175,260.00</b>	<b>4,978,200.00</b>
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	9,175,260.00	4,978,200.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>269,377,945.00</b>	<b>340,074,868.53</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>269,377,945.00</b>	<b>340,074,868.53</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>260,028,724.76</b>	<b>318,765,868.53</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>160,082,830.00</b>	<b>176,328,877.00</b>
210101	Үндсэн цалин	102,267,872.00	95,631,453.00
210102	Нэмэгдэл	45,008,343.00	62,283,563.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,711,714.00	1,507,000.00
210104	Урамшуулал	8,094,901.00	16,906,861.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,923,278.76</b>	<b>22,086,792.13</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,583,516.76	15,992,815.40
210202	Тэтгэмжийн даатгал	1,584,965.00	1,769,608.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,267,971.00	1,415,686.33
210204	Ажилгүйдлийн даатгал	316,989.00	264,424.06
210205	Эрүүл мэндийн даатгал	3,169,837.00	2,644,257.96
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,546,723.00</b>	<b>21,384,684.40</b>
210301	Гэрэл, цамилгаан	2,050,243.00	3,422,124.40
210302	Тулш, халаалт	17,496,480.00	17,962,560.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,136,120.00</b>	<b>21,555,000.00</b>
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	2,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,310,000.00	10,857,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	732,000.00	782,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	694,120.00	3,167,800.00
210406	Бага үнэтэй, турган алэгдэх, ахуйн эд зүйлс	2,200,000.00	4,547,300.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>23,609,437.00</b>	<b>54,975,004.00</b>
210501	Эм, балдыл, эмнэлгийн хэрэгсэл	13,818,460.00	42,302,072.00
210502	Хоол, хүнс	5,830,977.00	10,072,932.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,960,000.00	2,600,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,488,000.00</b>	<b>18,170,750.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	400,000.00	8,320,000.00
210602	Тавигга	-	4,000,000.00
210604	Урсгал засвар	1,088,000.00	5,850,750.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>976,000.00</b>	<b>659,986.00</b>
210702	Дотоод албан томилолт	976,000.00	659,986.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,811,236.00</b>	<b>491,175.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,347,286.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,500.00	52,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>15,455,100.00</b>	<b>3,113,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,455,100.00	3,113,600.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,349,220.24</b>	<b>21,309,000.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,647,035.00</b>	<b>21,300,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,647,035.00	21,300,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>123,777.00</b>	<b>9,000.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	123,777.00	9,000.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,578,408.24</b>	<b>-</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,578,408.24	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>463,213.00</b>	<b>8,518,086.47</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>463,213.00</b>	<b>8,518,086.47</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>8,518,086.47</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	286,675,800.00	273,951,692.13
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	286,675,800.00	273,951,692.13
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	283,175,800.00	270,451,692.13
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	176,376,000.00	169,387,761.00
210101	Үндсэн цалин	98,304,300.00	95,104,837.00
210102	Нэмэгдэл	62,700,100.00	61,623,563.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,276,000.00	1,507,000.00
210104	Урамшуулал	12,095,600.00	11,152,361.00
210105	Гэрээг ажлын хөлс		
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25,330,200.00	21,201,027.13
210201	Тэтгэврийн даатгал	17,415,100.00	15,384,694.40
210202	Тэтгэмжийн даатгал	1,978,800.00	1,700,197.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,583,000.00	1,360,157.33
210204	Ажилгүйдлийн даатгал	395,800.00	250,542.06
210205	Эрүүл мэндийн даатгал	3,957,500.00	2,505,435.96
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,546,100.00	19,582,463.00
210301	Гэрэл, цахилгаан	3,500,000.00	3,422,124.40
210302	Түлш, халаалт	17,046,100.00	16,160,338.60
210303	Цэвэр, бохир ус		
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,239,900.00	18,134,200.00
210401	Бичиг хэрэг	2,200,000.00	2,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,857,900.00	10,857,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	732,000.00	782,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хоргон мэрэгчдийн устгал, ариутгал	1,750,000.00	1,820,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,700,000.00	2,474,100.00
2105	<b>Нормативт зардал</b>	22,431,000.00	21,029,316.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,000,000.00	12,598,484.00
210502	Хоол, хүнс	5,831,000.00	5,830,832.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,600,000.00	2,600,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,790,800.00	17,850,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000.00	8,000,000.00
210602	Тавилга	4,000,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	4,790,800.00	5,850,750.00
2107	<b>Томиолт, зочны зардал</b>	557,800.00	410,000.00
210702	Дотоод албан томиолт	557,800.00	410,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	539,000.00	491,175.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	65,000.00	52,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	35,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	15,000.00	-
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,365,000.00	2,365,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,365,000.00	2,365,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	3,500,000.00	3,500,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,500,000.00	3,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	3,500,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	286,675,800.00	282,469,000.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	252,162,900.00	252,162,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	252,162,900.00	252,162,900.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	25,336,900.00	25,327,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	25,336,900.00	25,327,900.00
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	9,176,000.00	4,978,200.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	9,176,000.00	4,978,200.00
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>8,517,307.87</b>

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>66,114,176.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>66,114,176.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>48,314,176.40</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>6,941,116.00</b>
210101	Үндсэн цалин	526,616.00
210102	Нэмэгдэл	660,000.00
210104	Урамшуулал	5,754,500.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>885,765.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	608,121.00
210202	Тэтгэмжийн даатгал	69,411.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	55,529.00
210204	Ажилгүйдлийн даатгал	13,882.00
210205	Эрүүл мэндийн даатгал	138,822.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,802,221.40</b>
210302	Түлш, халаалт	1,802,221.40
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,420,800.00</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,347,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,073,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>33,945,688.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,703,588.00
210502	Хоол, хүнс	4,242,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>320,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	320,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>249,986.00</b>
210702	Дотоод албан томилолт	249,986.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>748,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	748,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>17,800,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,800,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,800,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>66,114,955.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>66,114,955.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	66,114,955.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	778.60

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванбаян тосгоны ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванбаян тосгоны ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Сумын ЭМТ нь эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванбаян тосгоны ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн

тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 282.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гурванбаян тосгоны ЭМТ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 119.2 сая төгрөгөөр буюу 24.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.0	2.0	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	8,518.1	8,518.1
Авлага	463.2	42,994.1	42,530.9
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	36,725.8	44,644.5	7,918.7
Нөөцийн бараа	-	10,198.7	10,198.7
Үндсэн хөрөнгө	209,565.8	205,941.3	(3,624.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>246,754.9</b>	<b>312,296.6</b>	<b>65,541.8</b>
Өр төлбөр	-	5,120.8	5,120.8
Засгийн газрын сан /Орон нутгийн сан	77,796.9	77,796.9	-
Өмнөх үеийн үр дүн	77,994.3	77,994.3	-
Тайлант оны үр дүн		60,421.0	60,421.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	90,963.7	90,963.7	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>246,754.9</b>	<b>312,296.6</b>	<b>65,541.8</b>
<b>Нийт орлого /Үр дүнгийн тайлан</b>	<b>280,001.4</b>	<b>419,598.9</b>	<b>139,597.4</b>
<b>Нийт зардал /Үр дүнгийн тайлан</b>	<b>273,566.1</b>	<b>359,177.9</b>	<b>85,611.8</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 8.5 сая төгрөг болж өссөн нь тайлант онд төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 44.6 сая төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт орж ирээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 44.6 сая төгрөг болж 7.9 сая төгрөг, нөөцийн бараа 10.2 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь короновируст халдварын үед хэрэглэх эм, хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлж ажиллаж байгаатай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 205.9 сая төгрөг болж 3.6 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд дээд шатны байгууллагаас 17.6 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй

шилжиж ирсэн, батлагдсан төсвөөс 10.0 сая төгрөгийн худалдаж авсан үндсэн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын сан дансны үлдэгдэл 77.8 сая төгрөг байна. Тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 419.6 сая төгрөг болж, өмнөх оноос 139.6 сая төгрөгөөр буюу 49.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 359.2 сая төгрөг болж, өмнөх оноос 85.6 сая төгрөгөөр буюу 31.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, норматив зардал, хангамж, бараа материалын зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна. Энэ нь короновируст халдварын дэгдэлттэй холоотой илүү цагийн хөлс, эм эмнэлгийн хэрэгсэл, хоол, эмч ажилчдад олгосон нэг удаагийн тэтгэмж, урамшуулал зэрэг зардлууд өссөнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тайлант онд орон нутгийн төсвөөс 25.3 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 9.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 252.2 сая төгрөг, нийт 286.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээс 252.2 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 5.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 25.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үүнээс урсгал үйл ажиллагаанд 273.9 сая төгрөгийг зарцуулж, мөнгөн хөрөнгийн дансанд 8.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Төсвийн гүйцэтгэл 95.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд ЭМДС-аас короновируст халдвараар тусгаарлах байрны хэвтэн эмчлүүлэгчдийн санхүүжилт 27.2 сая төгрөг, дархлаажуулалтын вакцины санхүүжилт 7.8 сая төгрөг, эрүүл мэндийн ажиллагсад олгох нэг удаагийн тэтгэмжийн санхүүжилт 17.8 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 10.6 сая төгрөг, нийт 66.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

- ✓ Эрүүл мэндийн төвийн чиг үүрэгт хамааралгүй, эмийн сангийн үйл ажиллагаа явуулж нэмэлт санхүүжилтийн дансанд 12.0 сая төгрөгийн эмийн орлого, зарлагын гүйлгээг бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34 “Төсвийн байгууллага гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг” гэж заасантай нийцэхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 252.2 сая төгрөгийн 5, худалдан авалтын 55.7 сая төгрөгийн 5 мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв байршуулж ажилласан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны аудитаар 1 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 100 хувь байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал бүртгэгдээгүй.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 68.8 сая төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс 54.4 сая төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулж, 14.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

##### **4.2.1 Залруулсан алдаа**

ЭМДС-аас авах авлагыг 42.8 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан, үндсэн хөрөнгийн элэгдлийг 11.6 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн зэрэг 2 алдааг санхүүгийн тайланд залруулав.

##### **4.2.2 Албан шаардлага**

- Нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтыг үндэслэн хөтлөөгүй ажил олгогчоос төлөх НДШ -ийн зардал 1.0 сая төгрөг төгрөг, эмийн зардал 1.4 сая төгрөгийн дансны бичилтийг алдаатай хийж цалингийн зардалд бүртгэсэн.
- Эрүүл мэндийн төвийн чиг үүрэгт хамааралгүй, эмийн сангийн үйл ажиллагаа явуулж нэмэлт санхүүжилтийн дансанд 12.0 сая төгрөгийн эмийн орлого, зарлагын гүйлгээг бүртгэсэн зэрэг зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Эрүүл мэндийн төв	4	68.8	2	54.4			2	14.4		
<b>Дүн</b>		<b>4</b>	<b>68.8</b>	<b>2</b>	<b>54.4</b>			<b>2</b>	<b>14.4</b>		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн Гурванбаян тосгоны Эрүүл мэндийн төв	0	0					0	0		
<b>Дүн</b>		<b>0</b>	<b>0</b>					<b>0</b>	<b>0</b>		
<b>Нийт дүн</b>		<b>4</b>	<b>68.8</b>	<b>2</b>	<b>54.4</b>			<b>2</b>	<b>14.4</b>		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 144

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Гурванбаян тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн төвийн чиг үүрэгт хамааралгүй, эмийн сангийн үйл ажиллагаа явуулж нэмэлт санхүүжилтийн дансанд 12.0 сая төгрөгийн эмийн орлого, зарлагын гүйлгээг бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34 “Төсвийн байгууллага гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн, алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өөрийн үйл ажиллагааны чиглэлд хамааралгүй эмийн эргэлтийн сангийн орлого, зарлагыг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулдаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гурванбаян тосгоны Эрүүл мэндийн төвийн дарга Б.Тэмүүжин, нягтлан бодогч Б.Анхтуяа нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЕРКЕГҮЛ

Д.ОЮУНТУЯА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 09

Дугаар 145

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Өмнөдэлгэр сумын Гурванбаян тосгоны Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтыг үндэслэн хөтлөөгүй ажил олгогчоос төлөх НДШ -ийн зардал 1.0 сая төгрөг төгрөг, эмийн зардал 1.4 сая төгрөгийн дансны бичилтийг алдаатай хийж цалингийн зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цалингийн зардлын нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтыг үндэслэн хөтөлдөггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гурванбаян тосгоны Эрүүл мэндийн төвийн дарга Б.Тэмүүжин, нягтлан бодогч Б.Анхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЕРКЕГҮЛ

Д.ОЮУНТУЯА

